

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

“Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” асуудлыг боловсруулан Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас Авлигатай тэмцэх газрын албан хаагчид, Шүүхийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 30 хувиар нэмэгдүүлэх; “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишиг”-ийг шинэчлэн тогтоох, түүнчлэн “Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээ”-г энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинэчлэн тогтоохыг асуудлыг хэлэлцэн дэмжээд холбогдох шийдвэрийн төслүүдийг Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

Улс төрийн албан тушаал эрхэлдэг баг, хороо, сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын цалингийг жишгийг шинэчлэн тогтоох асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 173 дугаар тогтоолоор батлуулав. Уг тогтоолыг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөх юм.

“Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 174 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв. Тогтоолыг 2007 оны 10 дугаар сарын 1-нээс мөрдөж эхлэх бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 80000 төгрөг буюу нэг цагт 474 төгрөг 38 мөнгө байхаар тогтоогоод байна.

Засгийн газраас нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс сард 80000 төгрөг байхаар шинэчлэн тогтоох болсонтой холбогдуулан нөхөн олговрын доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 8250 төгрөг буюу 16 хувиар нэмэгдүүлэн 60000 төгрөг болгох асуудлыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас уг асуудлыг хэлэлцээд холбогдох шийдвэрийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын даргын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан юм. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь хэлэлцэн тохирогч талуудын хуулийн этгээдүүдийн хооронд байгуулсан эсхүл байгуулах, Ажиллах хүч харилцан солилцох гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх, ажиллах хүч харилцан солилцох асуудлыг зохицуулахад оршиж байна. Хэлэлцээрийн хүрээнд 40 мянган айлын орон сууц, Мянганы зам зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудад нарийн мэргэжлийн ажиллах хүч, мэргэжилтэн дутагдалтай байгааг харгалзан талууд харилцан тохиролцсон эдийн засгийн тодорхой салбаруудад ажиллах хүч авах юм.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 13.1.5-д заасны дагуу “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Засгийн газраар батлуулахаар тогтоолын төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудын санал аваад байна.

“Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай” Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 177 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Уг тогтоолоор 36 дугаар тогтоолд “БНСУ-д ажиллах хүч зуучлан гаргах үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий төрийн өмч

давамгайлсан хуулийн этгээдийг энэ ажлыг эрхэлж байсан байгууллага, компаниудтай хамтран байгуулан ажиллуулах” гэсэн өөрчлөлт оруулав.

Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөхдөө хууль тогтоомжийн ойлгомжгүй байдал, давхардал хийдэгдлийн улмаас даатгалын тогтолцооны гадна үлдэж байгаа ажиллагчдын томоохон бүлгүүдийг заавал болон сайн дураар даатгуулах хэлбэрийн аль алинаар хамруулах боломжийг нэмэгдүүлэхийг зорьж зарим нэг агуулгын өөрчлөлт оруулав.

Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах үндэслэлийн талаар өргөн хүрээний судалгаа хийж, дэлгэрэнгүй мэдээлэл боловсруулж Ерөнхий сайдад хүргүүлэв.

2007 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар тэтгэврийн даатгалын санд нийт 111.63 тэрбум /өссөн дүнгээр/ төгрөгийн шимтгэлийн болон төсвийн татаасын орлого хуримтлагдаж, нийт 112,78 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 110.2 хувиар буюу 14 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, өссөн дүнгээр 150.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх сараас 0.6 тэрбум төгрөгөөр өсч 12.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 121 ба түүнээс дээш хоногоор хуримтлагдсан нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага нийт өр авлагын 53.2 хувийг эзэлж байна.

2007 оны 7 сарын 1-ний байдлаар Нийгмийн халамжийн санд нийт 49.5 тэрбум төгрөг хуримтлагдаж, Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, арга хэмжээ үйлчилгээнд нийт 40.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2007 оны эхний 6 сард Нийгмийн халамжийн арга хэмжээ, үйлчилгээнд нийт 1302.7 мянган хүн хамрагдсанаас 1083.6 мянга буюу 84.3 хувь нь улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжинд, 45.0 мянга буюу 3.4 хувь нь халамжийн тэтгэвэрт, 62.3 мянга буюу 4.8 хувь нь Нөхцөлт мөнгөн тэтгэмжинд, 71.2 мянга буюу 5.5 хувь нь Ахмад настан, ХБИ-дэд олгосон хөнгөлөлтөнд, 10.7 мянга буюу 0.8 хувь нь бусад үйлчилгээнд хамрагдсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 31.8 мянга болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 1402 хүнээр буюу 4.2 пунктээр буурч, ажилгүйдлийн түвшин 3.1 хувьтай байна.

Ажил хайгчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж нийт 38547 ажилгүй иргэдийг хамруулсан байна. 2007 оны эхний 6 сарын байдлаар нийт 26379 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4861 хүнээр буюу 22.6 пунктээр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд ажил олгогчдоос нийт 34300 ажлын байрны захиалга ирүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9902-оор буюу 40.6 пунктээр нэмэгдсэн байна.

Боловсролын салбарт:

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын хэмжээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

Боловсролын хөгжлийн хөтөлбөр 2-оос аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 180 сургуульд хими, биологи, физикийн лабораторийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна.

Засгийн газар хоорондын хэлэлцээрээр ОХУ-д бакалавр, магистрантурт суралцахаар материал хүргүүлсэн хүмүүсээс 54 хүнийг суралцуулах болсон тухай албан ёсны хариу ирээд байна.

Өндөр хөгжилтэй оронд сургалтын төрийн сангийн зээлээр хүн сургах эрх бүхий газруудаас нийт 9 хүнийг суралцуулах тухай шийдвэр гарав.

Англи хэлний багш нарын зуны сургалтын төлөвлөгөөг батлав. Сургалтыг АНУ-ын Энх тайвны корпусын сайн дурын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Орхон, Архангай, Хэнтий, Баян-Өлгий, Говь-Алтай аймаг, Улаанбаатар хот гэсэн 6 газарт зэрэг явуулж бүх аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудаас 150 багшийг хамруулав.

Эмзэг бүлгийн өрхийн хүүхдэд сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичиг олгох хяналтын тоог аймаг, нийслэлээр гарган аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газруудад хүргүүлэв.

2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журам”-ыг шинэчлэн боловсруулав.

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх графикийн төслийг боловсрууллаа. 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах, 2011-2012 оны хичээлийн жилээс дунд, ахлах ангиудыг 12 жилийн сургалтын шинэ төлөвлөгөөгөөр хичээллүүлэх, 2013-2014 оны хичээлийн жилд 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлэхээр төлөвлөж байна.

Их Монгол улс байгуулагдсаны 801, Ардын хувьсгалын 86 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны төлөвлөгөөний дагуу Баяр наадмын нээлтийн ёслол, хүндэтгэлийн концерт, Улаанбаатарын үдэш арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

ЮНЕСКО болон Монгол улсын Засгийн газраас хамтран зохион байгуулж буй “Боловсрол, соёлын явуулын үйлчилгээг Монголын малчдад хүргэх нь” төсөл хэрэгжиж буй 10 сумын төслийн багт 10 ширхэг УАЗ 469 машиныг хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгуулав.

“Соёлын олон төрөл зүйлийн илэрхийллүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцид Монгол улс нэгдэн орох тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлэв.

Шинжлэх ухаан, технологийн чиглэлээр гадаад оронд магистр, доктор бэлтгэх талаар мэргэжлийн боловсролын газартай тохиролцон хими, хими технологийн чиглэлээр Чех Улсад 4, бусад чиглэлээр ОХУ-д суралцах 10 хүнийг шалгарууллаа.

Улсын захиалгаар 2008 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөл, тэдгээрийн санхүүжилтийн хэмжээ, 2008 оноос эхлэн хэрэгжүүлэх шинжлэх ухааны суурь судалгааны сэдэвт ажлууд, тэдгээрийн санхүүжилтийн хэмжээг батлав.

“Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс” суурь судалгааны сэдэвт ажыг 2007-2008 онд хэрэгжүүлэхээр боллоо.

Монгол Улсын БСШУЯ, БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамны хооронд шинжлэх ухаан технологийн салбарт 2006-2010 онд хамтарч ажиллах хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан зөвлөлийн анхдугаар хуралдааныг хийлээ.

Эрүүл мэндийн салбарт:

Монгол улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар эмнэлгүүдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцын аргаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам, нэг даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээний суурь тариф, өртөг ойролцоо оношийн бүлгийн коэффициент, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээг санхүүжүүлэх хэмжээ, нэг даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг нэг тохиолдлоор санхүүжүүлэх хэмжээг тус тус батлав.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрэм, удирдлага зохион байгуулалтын бүтцийг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 196 тоот тушаалаар батлав.

2006 онд улсын хэмжээнд эмнэлгийн эмийн санд судсаар сэлбэх ариун шингэн бэлтгэх эмийн үйлдвэрлэл явуулж буй байдалд Улсын мэргэжлийн хяналтын газраас хийсэн шалгалтын дүнг үндэслэн, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS-5524:2005” улсын стандартын шаардлага хангахгүй байгаа судсаар сэлбэх ариун шингэнийг эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэхийг 2008 оны 3 сарын 1-нээс зогсоохыг аймаг, орон нутгийн эмнэлгийн дарга нарт даалгав.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 202 тоот тушаалаар Улаанбаатар хотын хувийн хэвшлийн эрүүл мэндийн орыг 2007 оны 7 сарын 16-ны өдрөөс 100 ороор нэмэгдүүлэв.

5000 гаруй сүрьеэтэй өвчтөний эмэнд шаардагдах 184.2 сая төгрөгийг 2007 оны төсвийн тодотголд тусгах замаар шийдвэрлээд байна.

2007 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах вакцин, биобэлдмэлийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулаад байна.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд гарсан балнад өвчний голомтын халдвар эсэргүүцэх арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллав.

Улаан бурхан өвчнийг эрс бууруулах үндэсний стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан ЭМЯ-ны Халдварт өвчин-тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Халдварт өвчний дэгдэлтийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний талаар 3 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 120 гаруй эмч, мэргэжилтнийг хамруулав.

Энэ сарын байдлаар улсын хэмжээнд 89-170 нэрийн 1.01 тэрбум төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлтэй байна.

Монголэмимпекс ХХК-ны агуулахад 170 нэрийн 596.6 сая төгрөгийн, хөдөө орон нутгийн эм хангамжийн компанийн агуулахад 89-141 нэрийн 568.5 сая төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эм байна.

Энэ сард импортын гэрээгээр Данийн Ново-Нордиск компаниас 4 нэрийн 20.5 мянган ам.долларын Инсулин, ОХУ-ын БурятФармация компаниас 23 нэрийн 80.1 мянган ам.долларын Үндэсний зайлшгүй шаардлагатай эм, Итали улсын Артасана компаниас 11 нэрийн 3.5 мянган ам.долларын эмнэлгийн хэрэгсэл, Хятад улсын ТМН компаниас 5 нэрийн 4.8 мянган ам.долларын эмийн түүхий эд, ороох боох материал нийлүүлэгдсэн байна.

Эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудад шаардлагатай Үндэсний зайлшгүй шаардлагатай эм тендерээр нийлүүлэгдэж, эмийн хангамж хэвийн байна.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын “Экспорт-импорт” банк хооронд байгуулсан “Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах байгууламж”, “Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ” төслүүдийн зээлийн гэрээ болон Засгийн газар хоорондын Тохиролцооны баримт бичгийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр болов. “Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг хянах байгууламж” төслийг БНСУ-ын Засгийн газраас олгох 12.8 сая ам.доллартай тэнцэх хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх юм.

Монгол Улсын Засгийн газар “Айвенхоу майнз Монголиа Инк” ХХК-ний хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл, Монгол Улсын Засгийн газар “Энержи Ресурс” ХХК-ний хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн бариад байна.

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишиг болон зарим албан тушаалын цалингийн жишиг, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, төрийн албан хаагчдын цалинг 30 хувь нэмэх шийдвэр гаргалаа. Энэ шийдвэрийг 2007 оны аравдугаар сарын 1-нээс эхлэн мөрдөх бөгөөд ингэснээр төрийн албан хаагчдын сарын дундаж цалин 211.9 мянган төгрөгт хүрнэ. Үүнтэй холбогдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 16 хувиар нэмэгдүүлэн сард 80.000 төгрөг буюу цагт 474 төгрөг 38 мөнгө болгохоор тогтлоо.

“Суруга Монгол” ХХК-тай байгуулах “Тогтвортой байдлын гэрээ”-ний тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, уг гэрээнд гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олгохоор тогтсон байна. Тогтвортой байдлын гэрээний төсөлд “Суруга Монгол” ХХК 2007 оны наймдугаар сараас 2012 оны наймдугаар сар хүртэл хугацаанд нийтдээ 100 сая долларын хөрөнгө оруулалт хийхээр тусгасан байна.

Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлд хамруулах саналыг зарчмын хувьд дэмжиж, УИХ-ын холбогдох байнгын хороогоор зөвшөөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Энэхүү төслийн зээлийг Автобус-1 нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийтдээ 120-150 тооны их багтаамжийн автобус авахаар тооцжээ.

Монгол Улсын Засгийн газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн хооронд байгуулсан Кувейт Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Парламентын ордон” барих төслийн Харилцан ойлголцлын санамж бичгийн тухай гэрээг УИХ-аар хэлэлцүүлэн батлууллаа.

Монгол Улсын Засгийн газар “Бороо гоулд” ХХК-тай байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлаар эцэслэн тохиролцож, түүнд гарын үсэг зурах бэлтгэлийг хангаж ажиллав.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын 2005-2006 оны хэрэгжилтийн тухай Үндэсний хоёр дахь илтгэлийн төслийг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд байгуулагдсан Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг боловсруулах, сайжруулах үүрэг бүхий Удирдах зөвлөл, Ядуурлыг бууруулах дэд хороогоор тус тус хэлэлцүүлээ. Удирдах зөвлөлийн хурлын үеэр илтгэл болон УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах чиглэлээр гарсан саналыг тусган Мянганы хөгжлийн хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2006 оны төсвийн гүйцэтгэлийг УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар Монгол Улсын 2006 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай УИХ-ын тогтоолоор Монгол Улсын 2006 оны улсын төсвийн гүйцэтгэлийн орлогыг 1,299,432,732.8 мянган төгрөгөөр, зарлагыг 1,176,658,906.0 мянган төгрөгөөр тус тус баталж, Монгол Улсын 2006 оны улсын төсвийн зарлагаас давсан орлого буюу улсын төсвийн ашиг 122,773,826.8 мянган төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх санд шилжүүлэн зарцуулахыг зөвшөөрсөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсөвт 2007 оны эхний хагас жилийн байдлаар нийт орлого 737,3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 56,3 тэрбум төгрөгөөр буюу 8,3 хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 210,0 тэрбум төгрөгөөр буюу 39,8 хувиар илүү байна. Зарим барааны үнийн өсөлтийн албан татвараас 107,9 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсний 98.4 хувийг буюу 106,2 тэрбум төгрөгийг Эрдэнэт улсын үйлдвэрийн газар оруулсан байна.

Аж ахуйн нэгжийн албан татварын дарамтыг багасгах, ачааллыг бууруулах, татварын хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр хийсэн татварын шинэчлэлийн дүнд аж ахуйн нэгж, байгууллагын 2007 оны эхний хагас жилийн орлогын албан татвар 10,4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага 2007 оны эхний хагас жилийн байдлаар 639,4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зарлагын 83,5 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 234,4 тэрбум төгрөгөөр буюу 57,8 хувиар илүү байна. Засгийн газар 2007 оны нэгдүгээр сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалинг 20 хувиар, өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэх, улмаар нийгмийн халамж, үйлчилгээний нөхөн олговрын хэмжээг тэлэх дэс дараатай арга хэмжээ авсан явдал төсвийн зарлага нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) 81.4 тэрбум төгрөгт хүрч, 76.2 хувийн, түүнчлэн дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 76.1 тэрбум төгрөгт хүрч, 77.3 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын зарим ажлын тендер шалгаруулалт бэлэн болоогүйгээс хөрөнгийн зардлын санхүүжилт 10 гаруй тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 4.1 тэрбум төгрөгөөр давж, зарлага 9.1 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Орлогын төлөвлөгөөг Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон аймаг тасалсан бөгөөд бусад аймаг орлогын төлөвлөгөөг 3.2-67.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас нийтдээ 11.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 11.3 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд Сэлэнгэ аймаг улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1.4 тэрбум төгрөгөөр тасалсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2007 оны эхний хагас жилийн урсгал тэнцэл 207,8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 97,9 тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 120,5 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 62,4 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан байна.

Мянганы хөгжлийн зорилтуудыг орон нутагт туршилтын журмаар бэлтгэх ажлын нээлтийн ажиллагааны уулзалт, семинарыг Дундговь аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүрэгт тус тус зохион байгуулав. Энэхүү уулзалт, семинарын үеэр Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явцыг танилцуулж, түүнийг орон нутагт хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлдэг зарим улс орны ажлын туршлагыг ярилцаж, улмаар сонгосон аймаг, дүүрэгт 2007-2008 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, түүний зохион байгуулалтыг хэлэлцүүлж зөвшилцсөн байна.

Монгол-Австрийн Засгийн газар хоорондын эдийн засгийн хамтарсан комиссын гуравдугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Австри Улсаас хөгжлийн албан ёсны тусламж авдаг орнуудын тоонд Монгол Улсыг оруулах талаар санал солилцов. Монголын талаас хөгжлийн албан ёсны тусламжийг хариуцдаг агентлагтай идэвхитэй ажиллаж, хөгжлийн тусламж авах оновчтой чиглэл, төслийг санал болгохоор тохиролцоонд хүрсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хүмүүнлэгийн хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлэх 20.8 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хэлэлцээрт Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Швейцарын Хөгжлийн агентлагийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулав.

Үйлдвэр, худалдааны салбарт:

Нэг цэгийн үйлчилгээ төслийг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэв.

Үйлдвэр, худалдааны салбараас олгож буй зөвшөөрөл лицензийг цахим хэлбэрээр олгох төслийн хүрээнд яамны холбогдох мэргэжилтнүүдэд зориулсан “Зөвшөөрөл лицензийг цахим хэлбэрээр олгох программ хангамжийг хэрхэн ашиглах вэ” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулав.

Аж үйлдвэрийн цогц хөтөлбөрийн хүрээнд Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв дээр хэрэгжиж эхэлж байгаа “Зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварыг бэхжүүлэх” нь сэдэвт сургалт семинарыг зохион байгуулав.

Японы Сожицү Судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төлөөлөгчидтэй уулзаж, үйлдвэр, худалдааны салбарын хүрээнд хийгдэх судалгааны ажлуудын талаар санал солилцон хамтран ажиллахаар харилцан тохиролцов.

2006-2007 онд хэрэгжүүлж дууссан “Газар зүйн заалт ба Хөнгөлөлтийн шинэ ерөнхий системийг ашиглан Монголын экспортыг нэмэгдүүлэх” төслийн тайланг гаргав.

Монгол-Австрийн Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцож, үйлдвэр, худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах тухай санал тавьж хэлэлцүүлэв.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна.

Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн төслийг ЭЗБХ болон УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж байна.

ҮХЯ-ны захиалгаар 2004-2006 онуудад хэрэгжиж дууссан 18 ШУТ-ийн төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа байдлын тухай тайланг бэлтгэж БСШУЯ-нд хүргүүлэв.

Өвөрхангай, Архангай аймгийн зарим сумдад гол, горхи ширгэж байгаа асуудлаар дээрх аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг газар дээр нь шалгаж дүгнэлт гаргав.

Налайх дүүргийн нүүрсний уурхайд гарсан ослыг арилгах үеийн аврах ажиллагааны талаарх танилцуулгыг бэлтгэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулав.

Газрын тосны хайгуулын 17, 18 дугаар талбайд “Магнай трейд”, БНХАУ-ын “NPI” компаниудын Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөлүүдэд бүх яамдаас санал авч тусган, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Газрын тосны хайгуулын нээлттэй 13 талбайн гэрээлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлэв.

“Монгол Улсын чөлөөт бүсийн үзэл баримтлал”-ыг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, үзэл баримтлалын төсөл, танилцуулга боловсруулав.

Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, ОХУ-ын “Росатом”-ын хоорондын ураны эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалтын салбарт хамтран ажиллах Протоколыг хэрэгжүүлэх хүрээнд ажлын хэсгийн анхны уулзалтыг ОХУ-ын Москва хотод зохион байгуулав.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газраар хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

Байгаль орчны салбарт:

Хувиргасан амьд биетийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав.

Байгаль орчны мэдээллийн сангийн тухай хуулийн төсөл болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлэв.

Агаарын төлбөрийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулан яамдаас санал авч нэгтгэв.

Импортоор оруулсан дахин ашиглах боломжгүй бараа материал, хог хаягдалд төлбөр тооцох тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулав.

Орхон голын ус тасарч, загас жараахай олноор үхэх болсон шалтгааныг тодруулах хамтарсан ажлын хэсгийг Байгаль орчны дэд сайд, Үйлдвэр худалдааны дэд сайд, Улсын мэргэжлийн хяналтын дэд даргын хамтарсан удирдамжаар байгуулж ажилд нь оруулав.

“Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж, уг үйл ажиллагаанд 2008 онд болон цаашид шаардагдах зардлын асуудлыг шийдвэрлэв.

“Монгол улсын цөлжилтийн явц, шалтгаан, түүний эрч хүчийг сааруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт”, “Усны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, цаашдын зорилт” илтгэлүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Увс аймгийн Ховд сумын Гоожуурын хүрхрээ, Баян-Өлгий аймгийн Сагиль сумын Баянзүрх уул, Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Рэнчинлхүмбэ сумдын Жиглэгийн даваа, Дархадын хотгор, Баянхонгор аймгийн Жинст, Богд, Баянлиг, Баянговь сумдын Их Богд уул орчмын нийт 320 мянган га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг УИХ-д өргөн барьж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хурлаар дэмжүүлээд байна.

Говийн бага дархан цаазат газарт хууль бусаар алт олборлож буй үйлдлийг таслан зогсоож, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд илтгээд байна.

Говийн их ДЦГ-ыг Дэлхийн байгалийн өвд оруулах судалгааны ажлыг ШУА-ын зарим хүрээлэнтэй хамтран явуулж үндэслэлийг боловсруулаад байна.

Хэрэгжээд дуусч буй “Их говийн экосистем, түүний шүхэр зүйлийг хамгаалах” төслийн үр дүн, Говийн их дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай бусад аймгийн байгаль орчны албад, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын дарга нар танилцаж туршлага судлах ажлыг зохион байгуулав.

2007 оны ойг нөхөн сэргээх ажил болон “Ногоон хэрэм”-ийн зурвас байгуулах ажлын гүйцэтгэлийг урьдчилсан байдлаар нэгтгэхэд 4859 га талбайд ойг нөхөн сэргээх ажил хийж, 261 га талбайд “Ногоон хэрэм”-ийн ногоон зурвас байгуулсан урьдчилсан гүйцэтгэлтэй байна.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг Архангай, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Архангай аймаг, Нийсэлийн ногоон бүсийн ойд нийт 11150 га-д гүйцэтгэв.

Ой зохион байгуулалтын ажлын хээрийн хайгуул, судалгааны ажлыг Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдын нутагт хийж байна.

Туул голд загас жараахай их хэмжээгээр үхэж байгаа шалтгааныг тодруулахаар голын дагуу 9 үйлдвэрт үзлэг шалгалт хийж, дүгнэлт гаргаж байна.

Энэ сард бүс нутгийг хамарсан цаг агаарын аюултай болон онц аюултай үзэгдэл ажиглагдаагүй, хүчтэй салхи, цочир хүйтрэлтээр тус бүр нэг удаа, халалтаар давхардсан тоогоор 8 удаа сэрэмжлүүлэг мэдээ гаргаж таарц нь 73.1 хувьтай байв.

Олон улсын 191, орон нутгийн 256 нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилж, Чингис хаан олон улсын нисэх буудлын 9 цагийн урьдчилсан мэдээ 241 удаа зохиосноос таарц нь 91.1 % байна.

Ой хээрийн түймрийн голомтын мониторинг хийх ажлын хүрээнд 19 өдрийн 23 удаагийн мэдээгээр Төв аймгийн Мөнгөнморьт, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун сумдын нутагт давхардсан тоогоор 20 түймрийн голомтыг илрүүлэн зураглаж, веб хуудсанд тавих, орон нутагт дамжуулах, ОБЕГ-т мэдээлэх арга хэмжээ авлаа.

Барилга, хот байгуулалтын салбарт:

Барилгын тухай хуулийг УИХ-аас томилогдсон ажлын хэсэг дахин боловсруулалт хийж, Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэхээр бэлэн болгов.

Орон сууцны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албан хаагчийн орон сууцны дэд хөтөлбөрийг эцэслэн боловсруулж яамдаас санал авахаар хүргүүлэв.

Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал, бүтцийн анхны хувилбарыг боловсруулан, ажлын хэсгийн гишүүдээс санал авч байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулав.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Геодези, зураг зүйн холбоонд санал авахаар хүргүүлэв.

Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн захиргаатай хамтран тус бүсийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж, холбогдох яам, байгууллагуудаас санал авч, батлуулах ажлыг зохион байгуулав.

Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын хот болгон хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах зургийн даалгаврыг батлуулав.

Засгийн газрын бондын хөрөнгөөр орон нутагт баригдах бага, дунд орлоготой иргэд, 40, 8, 4 айлын орон сууцны тендерийн зарлаж, зарим гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа. 40 айлын орон сууцны барилга 19 аймагт ажлаа эхэлсэн ба 11 аймгийн барилгад 1099,2 сая төгрөгийн гүйцэтгэл ирж 792,2 сая төгрөгөөр санхүүжихээр хянагдаад байна. 4, 8 айлын орон сууцны барилга, 10 аймгийн 44 суманд ажил эхэлж 17 суманд 267,0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, 230,7 сая төгрөгөөр санхүүжихээр хянагдаад байна. Одоо 40, 4, 8 айлын орон сууцны барилгад 1022,9 төгрөгийн санхүүжилт хүлээгдэж байна.

40000 орон сууц хөтөлбөрийн хүрээнд баригдах эхний ээлжийн орон сууцны хорооллуудын дэс дарааллыг тогтоох, инженерийн хангамжийн хэрэглээг тооцох, хэрэгжүүлэх арга хэмжээг судалж тодорхойлох, шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог урьдчилсан байдлаар боловсруулах ажлын хэсэг холбогдох судлагаа, тооцоог хийн, тайланг эхний хувилбараар гаргав.

Богдхан дархан цаазат уулын тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзлэг шалгалт явуулж тайланг нэгтгэн сайдын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлэн болгов.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах 2-р шатны төслийн Удирдах хорооны хурлыг зохион байгуулж, хүлээгдээд байсан асуудлуудыг шийдвэрлүүлэв.

“Барилгын хэв хашмалын тулаасанд залуу мод хэрэглэхийг хориглох тухай” Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын хамтарсан тушаалыг гарган, түүнийг сурталчлах ажлыг зохион байгуулав.

Нийтийн аж ахуйн салбарын 2007-2008 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын талаархи танилцуулгыг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Британийн Колумбын Технологийн дээд сургуулийн харьяа Канадын Орон сууц, барилгын төв, Канадын Ойн аж ахуйн шинэ технологийн хөрөнгө оруулалтын агентлагийн төлөөлөгчидтэй уулзаж, Канадын модон барилгын технологийг нэвтрүүлэх талаар санамж бичиг байгуулав.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Төв Азийн бүсийн Эдийн засгийн хамтын ажиллагааны Тээврийн салбарын зохицуулах Хорооны 7 дугаар хурал, CAREC-ийн Тээврийн салбарын стратегийн 2 дахь зөвлөлдөх хуралдаанд оролцож, Төв Азийн орнуудын CAREC-4 чиглэлд “Авто зам, авто зам/төмөр зам” чиглэлээр буюу Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд, Ярант-Ховд-

Цагааннуур чиглэлээр нэгдэх саналыг тавьж, гишүүн орнуудын сайд нарын гарын үсэг зурах Санамж бичгийн төсөлд тусгуулав.

Засгийн газрын 2002 оны “Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчин явж буй тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто зам ашигласны төлбөр авах төлбөртэй цэгийн ажиллах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 169 дүгээр тогтоолыг гаргуулав.

Монгол Улсын Засгийн газар, Австрийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулахаар Австрийн талаас ирүүлсэн хэлэлцээрийн төсөлд санал өгч, хэлэлцээрийн төслийг 8 дугаар сард багтаан хэлэлцэн тохиролцохоор ажиллаж байна.

Төмөр замын тэврийн тухай хуулийг УИХ-аар батлуулав. Уг хуулийг хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө гаргахаар ажиллаж байна.

“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай” Засгийг газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлуулах тухай хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Далай ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы эхний хэлэлцүүлэгт оруулж дэмжүүлсэн бөгөөд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын “Худалдааны далайн тээврийн салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрийг байгуулав.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам”-ын төслийг боловсруулан яамдын саналыг авч байна.

Шуудангийн нэгдсэн /зип/ кодыг байр зүйн зураг дээр оноох ажлыг Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, Улаанбаатар хотын Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрынхантай хамтран хийж дуусаад байна.

Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109км, Хөшөөцайдам-Өгийнуур чиглэлийн 10км хатуу хучилттай авто замын трассд орсон археологийн дурсгалыг хамгаалах зорилгоор Шинжлэн ухааны академийн Археологийн хүрээлэнтэй археологийн малталт хийх гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэв.

Кувейтийн сангийн хөнгөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн авто замын I, II хэсгийн барилгын ажлыг хүлээн авч авто замын хөдөлгөөнийг нээлээ.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 46.9км хайрган хучилттай авто замын 1-р багцад археологийн судалгаа хийх ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажлыг эхлүүлэв.

Энэ онд улсын хэмжээнд үзлэгт тоологдсон нийт 198047 тээврийн хэрэгслийн 157473 нь буюу 79.5 хувь, үүний дотор Улаанбаатар хотод тоологдсон 93316 тээврийн хэрэгслийн 80123 буюу 85.8 хувь, орон нутгийн 104731 тээврийн хэрэгслийн 77350 буюу 73.8 хувь нь техникийн хяналтын үзлэг, оношлогоонд хамрагдаад байна.

Зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох ажлыг зохион байгуулав. 1-5 одын зэрэглэлээр хүсэлт гаргасан 11 зочид буудал, 1-2 цэцгийн зэрэглэлээр хүсэлт гаргасан 6 жуулчны баазад зэрэглэл тогтоох ажлыг хийв.

2007 оны эхний 6 сарын байдлаар Монгол Улсад 156 орны 164073 гадаадын жуулчид ирсэн байна. Үүнийг 2006 оны мөн үетэй харьцуулж үзвэл 14275 буюу 8.7 хувиар өссөн байна.

Түлш, эрчим хүчний салбарт:

Түлш, эрчим хүчний салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2007-2009 онд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдох 5 сумын техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж шийдвэрлэв.

“Улаанбаатар цахилгаан түгээх станц” ХК-ийн Сонгинохайрхан дүүргийн Баянхошууны гэр хорооллын хэрэглэгчдэд үйлчлэх төвийг шинээр байгуулж нээлтийг хийлээ. Энэхүү шинэ төвөөр тус дүүргийн 14000 орчим хэрэглэгчид үйлчлүүлэх юм.

Түлш, эрчим хүчний салбарын байгууллагуудын 2007-2008 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, санхүүгийн хүндрэлээс шалтгаалан өвөлжилтийн бэлтгэл нь удааширч байгаа Даланзадгадын дулааны цахилгаан станц, Багануурын дулааны станц, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрт Засгийн газраас хөрөнгө гарган өвөлжилтийн бэлтгэлийг хангахаар болов.

Дулааны цахилгаан станцуудын их ба урсгал засвар, хөрөнгө оруулалтын ажлын биелэлтэнд хяналт тавин, мэргэжлийн заавар, зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна.

Ховдын Манхан, Мөнххайрхан сумдын усан цахилгаан станцуудын далангийн засварын ажлыг дуусган орон нутагт нь хүлээлгэн өгөх арга хэмжээг зохион байгуулав.

Дорноговь аймгийн Мандах суманд гүйцэтгэсэн салхи-дизель хосолсон цахилгаан станцанд техникийн комисс ажиллаж, ажлын комисс ажиллах хүртэлх хугацаанд дутуу ажлуудыг гүйцээх үүрэг даалгавар өгөөд байна.

Дөргөний усан цахилгаан станцын ус дөхүүлэх болон ус хаях сувгийн барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, хуваарийн дагуу 7 дугаар сарын 1-нд Чоно харайх голын усыг станцын ус хаюурын суваг руу шилжүүлэн урсгах ажлыг зохион байгууллаа.

“Эрчим хүчний төсөл”, “Эрчим хүчний хөтөлбөр-1 төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн болон Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын ашиглалтын өмнөх захиргааны үйл ажиллагааны зардлыг хянан нийт 33.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Улсын төсвөөс алдагдлын санхүүжилт авдаг дизель станц бүхий Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэр, Даланзадгадын дулааны цахилгаан станцад 7 дугаар сарын хуваарьт санхүүжилт болох 320,69 сая төгрөгийг олгууллаа.

Монгол-Австрийн эдийн засгийн харилцааны Засгийн газар хоорондын хамтарсан комиссын гуравдугаар хуралдааныг Гадаад хэргийн яамтай хамтран зохион байгуулж, уулзалтын тэмдэглэлд хоёр орны төлөөлөгчдийн тэргүүнүүд гарын үсэг зурлаа.

Эдийн засгийн харилцааны Монгол-Унгарын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын анхдугаар хуралдааны тэмдэглэлийн мөрөөр 2006-2007 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Түлш, эрчим хүчний яам, Унгарын “Magyar Projekthaz Kft” ХХК-тай хамтран салбарын мэргэжилтнүүдийг давтан мэргэшүүлэх сургалтын программ боловсруулж хэрэгжүүлэх, тэдгээрийн техникийн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар “Түлш, эрчим хүчний салбарын ажиллагсдын сургалт” нэртэй төсөл боловсруулан Сангийн яаманд хүргүүлээд байна. Мөн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын хоёрдугаар хуралдааны протоколд тусгуулах саналуудыг хүргүүлээд байна.

Австрали улсын Гадаад хэргийн сайдын Монгол улсад хийсэн айлчлалын үеэр уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны Монгол-Австралийн ажлын хэсэг байгуулахаар тохиролцсонтой холбогдуулан ажлын хэсгийн ерөнхий тохиролцооны төслийг боловсруулан Гадаад хэргийн яаманд хүргүүлээд байна.

Азийн хөгжлийн банкнаас Бээжин хотноо зохион байгуулсан “Эрчим хүчний стратеги боловсруулалтын сонирхогчдын зөвлөлдөх уулзалт”-нд оролцож Зүүн Азийн болон тус банкны донор орнуудад Монгол улсын Түлш, эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, бодлого, стратегийн талаар танилцуулж санал солилцлоо.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

Мал өвөлжилтийн бэлтгэлийг хангах арга хэмжээний тухай албан даалгаврыг гаргаж аймаг, нийслэлийн Засаг дарга болон хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт шуурхай хүргэх ажлыг зохион байгуулав.

ХХААЯ, Ургамал хамгааллын хүрээлэн, УМХГ хамтран Таримал ургамалд хөнөөл учруулж болзошгүй царцаа, хортон шавьж устгах талаар үзүүлэх сургалтыг үр тарианы чиглэлээр Сэлэнгэ аймгийн Сайхан сумын “ Ургацын ундраа” ХХК дээр зохион байгуулж 32 аж ахуйн нэгж, иргэн, төмс, хүнсний ногооны чиглэлээр Сэлэнгэ аймгийн Баянгол сумын “Хараа” ХХК дээр зохион байгуулж 70 гаруй аж ахуйн нэгж, иргэд тус тус хамрагдав.

Царцаатай тэмцэх арга хэмжээг Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Төв аймгийн царцаа тархсан сумдын бэлчээрт нийт 90.0 мянган га талбайд технологийн дагуу зохион байгуулав. Энэ арга хэмжээнд зориулж 2007 оны төсвийн хөрөнгөөр царцааны шингэн хор 27000 литр, царцааны хор шүрших жижиг техник бүхий бүхээгтэй бага оврын трактор 9 иж бүрдлийг нийлүүлж дээрх аймгуудад хуваарилан хүргүүлэв.

Төв аймгийн Баянчандмань сумын Хөх хошуу, Дархан-Уул аймгийн Ширээ нурууны услалтын системүүдийн эхний үе шатны ажлын санхүүжилтийг хийж, Хэнтий аймгийн Дархан сумын Цээлийн булаг, Увс аймгийн Зүүнговь сумын Харбураа, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Шинэстэйн услалтын системүүдийн эхний ээлжийн ажлын явцыг шалган санхүүжилт хийхэд бэлэн болов.

11 аймагт шинэ худаг барьж байгуулах, 7 аймагт худаг сэргээн засварлах ажлын гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэв. Нийт 6 аймагт шинэ худаг барих ажлын 13 гэрээний санхүүжилтийг Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс, 7 аймагт худаг сэргээн засварлах ажлын 8 гэрээний хөрөнгө, 5 аймагт шинэ худаг барьж байгуулах 10 гэрээний санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас ажлын гүйцэтгэгч нарт шилжүүлэв.

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн зарим сумдын үхэр сүрэгт түгээмэл гарч буй өвчлөл, хорогдлын шалтгааныг илрүүлэх, үзлэг шинжилгээ хийх, холбогдох дээж материал авах, оношлох, малын өвчлөл хорогдлыг бууруулах, эмчлэн сэргийлэх аргын зөвлөмж өгөх зорилгоор 13 суманд орон нутгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллав.

Мал эмнэлгийн бараа материал нийлүүлэх 2007 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу вакцин хадгалах хөргүүр, шүлхий өвчнөөс сэргийлэх вакцин, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэлийг орон нутагт хуваарийн дагуу хүргүүлэн нийлүүлэгчдэд санхүүжилтийг хийв.

Аргентин Улсын Бээжин дэх ЭСЯ-ны Хөдөө аж ахуйн зөвлөх болон Уругвай улсын ХААЯ-ны төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Санамж бичгийн төслийг хамтран боловсруулав.

Куба Улсаас өндөр ашиг шимт сүүний ямааны гүн хөлдөөсөн 5000 тун үр авахаар мал эмнэлгийн шаардлага, хяналт, хорио цээрийн талаарх мэдээллийг Кубын талд хүргүүлэв.

Усалгаатай тариалан, усжуулалтын чиглэлээр төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар НҮБ-ын ХХААБ-аас ирсэн судалгааны багтай хамтран Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт ажиллаж, усны нөөц, усжуулалтын одоогийн байдалтай танилцуулав.

Гадаад бодлогын чиглэлээр:

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Н.Энхболдод НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагын төлөөлөгч ноён Сажжад Ажмал Итгэмжлэх захидлаа гардуулав. Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагатай хамтран 8,06 сая ам. долларын өртөг бүхий Орны нэгдсэн хөтөлбөрийг 2007 оноос хэрэгжүүлж эхлээд байгаа

бөгөөд уг хөтөлбөр нь экспортын чиглэлтэй малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг ханган, өрсөлдөх чадварыг сайжруулах замаар ядуурлыг бууруулах зорилготой болно.

Хилийн чанадад сонгууль зохион явуулдаг эрх зүй, тогтолцоо, практикийн талаар судалгаа хийж Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх ажлын хэсэгт мэдээлэл хийв.

Германы эдийн засаг, технологийн сайд М.Глос айлчилж, Ерөнхий сайд, Сангийн сайд нартай уулзав. Айлчлалын үеэр Баварын Ландес банк, ХХБ-ын хоорондын Зээлийн Ерөнхий хэлэлцээр, Германы Тиссен Крупп концерн манай Монголиан Идастриал Корпорэшин компанийн хооронд Нүүрснээс шингэн түлш гаргах төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Санамж бичигт тус тус гарын үсэг зурав.

Монгол-Австрийн ЗГХК-ын 3 дугаар хуралдааныг зохион байгуулав. ХАА-н салбарт хамтран ажиллах Протокол, Киотогийн Протоколын хүрээнд хамтран ажиллах тухай БОЯ-дын хоорондын Протоколын төслийг австрийн талаас гардуулав. Эдгээр баримт бичигт Ерөнхий сайдын айлчлалын үеэр гарын үсэг зурахаар тохиров.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол, Болгарын ЗГХК-ын 4 дүгээр хуралдаанд манай тал 11 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг оролцуулав. Хуралдааны үеэр Комиссын монголын хэсгийн дарга, ҮХ-ны дэд сайд Я.Содбаатар Болгарын Эдийн засаг, эрчим хүчний дэд сайд, Гадаад хэргийн дэд сайд, Парламент дахь БМПБ-ийн дарга нартай уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцон холбогдох Протоколд гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Англи Улсад хийсэн айлчлалын дүнг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг яам, газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

БНАСАУ-ын АДХТ-ийн дарга Ким Ен Нам Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Монгол Улсад албан ёсны найрсаг айлчлал хийв. Айлчлалын үеэр Ким Ен Нам Монгол Улсын Ерөнхийлөгчтэй ганцаарчилсан уулзалт, яриа хэлэлцээ хийсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхболд, УИХ-ын дарга Д.Лүндээжанцан, УИХ дахь Монгол, Солонгосын парламентайн найрамдлын бүлгийн дарга Р.Бадамдамдин, Монгол-Солонгосын найрамдлын нийгэмлэгийн гишүүдтэй уулзав.

Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг конвенц, Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хамгаалах тухай конвенц, Бүтээгдэхүүний загварыг олон улсын бүртгэлийн Гаагийн хэлэлцээрийн 1999 оны Женевийн актад нэгдэн орох асуудлыг Засгийн газрын болон УИХ-ын АБГББХ-ны хуралдаанаар тус тус хэлэлцүүлэв.

АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын Ардчиллыг дэмжих комиссын гишүүд ажлын айлчлал хийв. Төлөөлөгчдийг Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар хүлээн авч уулзав.

Монгол Улсын Гадаад хэргийн сайд Н.Энхболдын урилгаар БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ян Жэчи Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Гадаад хэргийн сайд нар албан ёсны хэлэлцээ хийж, БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 50 сая юаний буцалтгүй тусламж үзүүлэх тухай хэлэлцээр, хоёр орны хамтарсан археологийн судалгааны ажилд зориулан 10 сая юаний буцалтгүй тусламж олгох хэлэлцээр, ШУА болон Хятадын ШУА-ийн Газар хөдлөлтийн хүрээлэнгийн хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт тус тус гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын дарга Д.Лүндээжанцан нар БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Гао Шумаог эх орондоо бүрмөсөн буцахтай нь холбогдуулан хүлээн авч уулзав.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга Лим Чхэ Жөн Монгол Улсын Их Хурлын дарга Д.Лүндээжанцаны урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Лим Чхэ Жөн Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхаж, УИХ-ын дарга

Д.Лүндээжанцантай уулзаж, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 86 жилийн ойн баярын нээлтийн ажиллагаанд оролцов.

2007 оны 7 дугаар сарын 10-17-ны хооронд Япон улсын угсаа залгамжлах Эрхэм дээд Хунтайж Нарухито Монгол улсад албан ёсны айлчлал хийв.

Батлан хамгаалах салбарт:

Сьерра Леон Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд цэргийн багийн дараагийн ээлжийг бэлтгэж оролцуулах тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Улсын нисэхийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн “Тусгай үүргийн нислэг үйлдэх журам”, “Онцгой үүргийн нислэг үйлдэх журам”-уудын төслийг боловсруулж байна.

“Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр орлуулан хаах болзол”, “Иргэн цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын төслүүдийг боловсруулж байна.

Монгол Улс, ХБНГУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын дээд хэмжээний зөвлөлдөх уулзалтад Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уламжлалт бус аюулын үед олон талт үүрэг гүйцэтгэх “Зориулалтын хүчин”, “Ерөнхий зохицуулалтын цэргийн мотобуудлагын ангиудын олон талт үүрэг гүйцэтгэх чадахийг нэмэгдүүлэх”, “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт сургаж бэлтгэх зориулалтаар Зэвсэгт хүчний ангиудын сургалтын төвүүдийг бүсийн сургалтын төв болгох” зэрэг дэд төслүүдийг боловсруулж байна.

“Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын зохион байгуулалтын заавар”-ыг батлуулж, зэвсэгт хүчний анги байгууллага, аймаг, нийслэл, дүүргүүдийн цэргийн штабуудад хүргүүлэв.

2006-2007 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер ахлагч нартай өөрийгөө хөгжүүлэх сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салааны жигдрэлтийг хангах сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчдын мэргэжлийн бэлтгэл, гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулав.

Сьерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй 3-р ээлжийн цэргийн бүрэлдэхүүнийг 4-р ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүнээр солих ажлыг зохион байгуулж байна.

Баруун Сахар, Конго, Судан, Этиоп, Эритри, Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд зэвсэгт хүчний 12 офицер цэргийн ажиглагчаар үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

“Хааны эрэлд-2007” олон улсын хамтарсан хээрийн сургуулийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Хууль зүйн чиглэлээр:

Улсын Их Хурлын чуулган болон байнгын хороодын хуралдаанаар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль болон Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус хэлэлцүүлж байна.

УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Я.Санжмятав нарын санаачилсан Экологийн ногоон бүсийн тухай, УИХ-ийн гишүүн Д.Дондог, Э.Бат-Үүл, Ц.Жаргал, Ц.Мөнх-Оргил, С.Оюун, С.Отгонбаяр нарын санаачилсан Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Ж.Наранцацралтын санаачлан боловсруулсан Хувийн шадар хамгаалалтын тухай хуулийн, УИХ-ын гишүүн Л.Гансүх, С.Ламбаа нарын санаачилсан Тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээ.

Транс Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

Монгол Улсын иргэнд эрхийн бичгээр газар өмчлүүлэх тухай, Холбоо, хяналт, мэдээллийн нэгдсэн сүлжээ төслүүдийг хэрэгжүүлэх төслийн зээлийн гэрээг соёрхон батлах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчны мэдээллийн сангийн тухай, Агаарын төлбөрийн тухай, Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг 8 хуулийн төслийн үзэл баримтлалыг хянаж батлав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хадгаламжийн даатгалын тухай хуулиудын төсөлд санал өгсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны Сибирийн холбооны тойргийн бүс нутгийн Хилийн удирдах газрын дарга И.С.Курилов тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад зориулсан ээлжит сургалт семинарыг зохион байгуулав.

Нээлттэй нийгэм форумтай хамтран иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд зориулсан “Иргэдийн эрх зүйн хөтөч” гарын авлагыг, эрх зүйн сургалт сурталчилгааны ажилтнуудад зориулсан “Эрх зүйн хөтөч-арга зүй” гарын авлагыг тус тус гаргав.

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр:

БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар тус улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн шугамаар хэрэгжих Засгийн газрын мэдээллийн нэгдсэн төв байгуулах төслийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг хийж харилцан тохиролцооны бичигт гарын үсэг зурлаа. Мэдээллийн нэгдсэн төв байгуулагдсанаар салбар бүрийн тусдаа байгаа мэдээллийн системүүд нэгдсэн зохион байгуулалтад орж, салбарууд ижил системээр журамлагдсан мэдээллийг харилцан солилцох, тэдгээрийг олон улсын стандартад нийцсэн аюулгүй байдлаар хангах боломж бүрдэх юм.

Засгийн газрын 2006 оны 251 дүгээр тогтоолын дагуу “Цахим нэг цонхны хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зорилгоор төрийн холбогдох байгууллагуудаас санал авах ажлыг эхлүүлээ.

Бүх нийтийн цахим бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисстой хамтран “Бүх нийтийн мэдээлэлжүүлэх хөтөлбөр”-ийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлууллаа. Үндэсний хороо нь бүх нийтийн цахим бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, мэдээлэлжсэн нийгмийг цогцлоон бүрдүүлэх зорилгоор нийгмийн бүх давхаргад чиглэсэн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм.

Ази, Номхон далайн Цахилгаан холбооны байгууллага болон МХХТГ, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл, харилцаа холбооны стандартчиллын олон улсын бага хурлыг зохион байгууллаа. Хурлын үеэр бүс нутгийн орнуудын мэдээлэл, харилцаа холбооны салбарын стандартчиллын өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, шинэ үеийн сүлжээ, үүрэн телефоны 3 дахь үе, интернэт телевиз, тээврийн ухаалаг систем, утасгүй технологийн стандартчиллын үйл ажиллагааны хөгжил зэрэг асуудлаар илтгэл тавьж хэлэлцсэн нь чухал ач холбогдолтой боллоо.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгууллага бүрийг вэбтэй, ажилтан бүрийг имэйлтэй болгох зорилтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Төрийн байгууллагуудын вэб, имэйл” төслийн хүрээнд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай хамтран монголын нөхцөлд тохируулан нутагшуулсан Жумла /Joomla/ агуулгын удирдлагын системийг танилцуулах семинар, системийн албан ёсны нээлтийн арга хэмжээг төр, захиргааны байгууллагын удирдах ажилтан, шийдвэр гаргах түвшний хүмүүсийг оролцуулан зохион байгууллаа.

“Мэдээлэл, харилцаа холбооны салбар 2007 онд” хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, орон нутгийн өгөгдлийн сүлжээ /DSL үйлчилгээ/-ний нээлтийг хийлээ. Энэ ажлын хүрээнд 21 аймаг, Багануур болон Налайх дүүрэг нийт 23 газар тус бүр 96 порт буюу нийт 2208 хэрэглэгчийн порт /DSLAM/ суурилуулж бэлэн болгосноор тухайн газар бүрт 96 хэрэглэгч интернэтийн өндөр хурдны үйлчилгээг хүртэх боломжтой боллоо.

МХХТГ-аас Улаанбаатар төмөр замтай хамтран интернэтийн урсгал оруулж ирдэг технологийг шинэчилж, DWDM шинэ технологи дээр суурилсан 2,5 гигабайтын нэмэлт урсгал үүсгэх бэлтгэл ажлыг хангаад байна. Нэмэлт урсгал бүрдүүлснээр 1 мегабайт интернэт урсгалын түрээсийн үнэ одоогийн 400 ам.доллараас 4 дахин бууж 100 орчим ам.доллар болох бөгөөд нийт багтаамж нь 5,2 дахин нэмэгдэх боломж бүрдэнэ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар